

*Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам*

*Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам*

*Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль*

*Гар бичмэлийн эрхтэй*

**Л.Энхсайхан**

**Бреф-мон биобэлдмэлийн ариун чанар ба  
ясанд үзүүлэх нөлөөг судалсан дүн**

*Е - 723800 Нүүр ам судлал*

*Улаанбаатар 2006 он.*

*Ажлын удирдагч: Анагаах Ухааны Доктор, Профессор Б.Оюунбат*

## Гарчиг

|                                               |       |
|-----------------------------------------------|-------|
| Товчилсон үгсийн жагсаалт:                    | 5     |
| Нэг. ОРШИЛ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ         | 6-7   |
| 1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО                       | 8     |
| 1.3. СУДАЛГААНЫ ЗОРИЛТ                        | 8     |
| Хоёр. СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ                  | 8     |
| Гурав. СУДАЛГААНЫ АЖЛЫН ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ  | 9     |
| Дөрөв. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ | 9-10  |
| Тав. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ                           | 11-21 |
| Зургаа. СУДАЛГААНЫ АЖЛЫН БҮТЭЦ                | 22    |
| Долоо. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ БА АРГА ЗҮЙ        | 23-28 |
| Найм. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН                 | 29-41 |
| Ес. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭЛЦЭМЖ                  | 42-44 |
| Арав. ДҮГНЭЛТ                                 | 45    |
| Ном зүй                                       | 46-52 |

**Товчилсон үгсийн жагсаалт:**

ЭМШУИС- Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль

НАСС-Нүүр Ам Судлалын Сургууль

НАЭ - Нүүр Амны Эмчилгээ

ЦА- Цустай агар

МкА- Мак-конки агар

ШТЭӨ - шүдний тулгуур эдийн өвчин

ДЭМБ – Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

## **Нэг. ОРШИЛ**

### **1.1 СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ**

Шүдний тулгуур эдийн өвчний тархалт жилээс жилд ихсэж тулгамдсан асуудлын нэг байсаар байна. 25-44 насны хүмүүст хийсэн судалгаагаар 95% нь шүдний тулгуур эдийн үрэвсэлт өвчтэй байгаа нь эмчилгээний үр дүнтэй арга боловсруулах шаардлагатай болохыг нотолж байна (Шашмурина, Аболмасов нар, 2002).

Германд 3 хүн тутмын нэг нь Шүдний Тулгуур Эдийн Үрэвсэлт Өвчний хүнд хэлбэрийн үрэвсэлтэй байгаа нь анхаарал татаж байна (Gerhard Hetz, нар, 2004).

Шүдний тулгуур эдийн тархмал үрэвслийн үед шүдний тулгуур эдэд цусны бичил эргэлтийн алдагдал ба хүчилтөрөгчийн дутагдал болж эрүү, хоншоорын ясны нөхөн төлжих чадвар нь эрс буурдаг. ШТЭӨ-ий үед шүд буйлны холбоос тасарч, шүд хоорондын таславч шимэгдэснээс шүд хөдөлгөөнд орж эрт унан эрүү шүдний согог, гажиг үүсэх, хоол боловсруулах болон бусад эрхтэн тогтолцооны өвчин үүсгэх гол шалтгаан нь болдог.

Манай оронд Норовпил Ц., (1983)., 8-17 насны 1000 хүүхдэд ШТЭӨ - ий тархалт 543,1. Өвчний бүтцээр үзвэл буйлны архаг үрэвсэл 86,4%, буйлны томролтот үрэвсэл 4,2%, шүдний тулгуур эдийн үрэвсэл 9,4%

байсныг тогтоожээ. ШТЭҮӨ нь 18-55 насны үйлдвэрийн ажилчдад 40-65,9%, оюутнуудын дунд 27,4% - ийг эзэлж байв.

Судлаач Батцэцэг. Ц (1996) ШТЭӨ- ий тархалт 84.37% байсан ба нас ахих тутам үрэвслийн үйл явц хүндэрч байсан боловч нийт хүмүүст хөнгөн хэлбэр (69,20+- 2,41% ) зонхилж байна.

Шүдний тулгуур эдийн өвчин нь нэгэнт эхэлсэн бол эргэшгүй, давшингуй явцтай эмгэг үүсгэдэг учир эмгэг явцыг зогсоох, гэмтэж шимэгдсэн шүдний холбоос болон түүшин сэртэнг сэргээх нь тулгамдсан асуудлын нэг байсаар байна.

Хэдийгээр шүдний тулгуур эдийн үрэвсэлт өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх аргачлал боловсруулагдан эмнэлэг үйлчилгээнд хэрэглэж байгаа боловч манай оронд түүшин сэртэнгийн шимэгдсэн ясыг нөхөн сэргээх эм бэлдмэл байхгүйгээс шүдний тулгуур эдийн үрэвсэлт өвчний улмаас шүдгүйдэл ихсэж байна.

Дэлхийн улс орнуудад энэхүү тулгамдсан асуудлыг улс орныхоо онцлогт тохируулан шийдвэрлэж шимэгдсэн түүшин сэртэнг нөхөн сэргээх янз бүрийн бэлдмэлүүдийг шүдний тулгуур эдийн үрэвсэлт өвчний эмчилгээнд хэрэглэснээр 80-95% нь үр дүнтэй байгааг хэвлэлийн тоймуудад мэдээлсэн байдаг (Wenz B., Marxer M.,2002).

Судлаач Б.Эрдэнэцогт ( 2003) өөрийн орны бүтээгдэхүүнээр Бреф-Мон биобэлдмэлийг хийж  $2,5 \cdot 10^6$  рад гамма туяагаар шарж ариутгасан боловч туршилт судалгааг хийж амжаагүй билээ.

Иймд бид уг биобэлдмэлийн туршилт судалгааг хийх болсон юм.

## **1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО**

Бреф-Мон биобэлдмэлийн ариун чанар ба түүний ясанд үзүүлэх нөлөөг судлахад оршино.

## **1.3 СУДАЛГААНЫ ЗОРИЛТ**

1. Бреф-Мон биобэлдмэлийн ариун чанарыг судлах
2. Бреф-Мон биобэлдмэлийн ясанд үзүүлэх нөлөөг туршилтын амьтан дээр судлах

## **Хоёр. СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ**

Манай оронд түүшин сэртэнгийн шимэгдэлтийг нөхөн сэргээх биобэлдмэлийг анх гарган авсан. "Бреф-Мон" биобэлдмэлийн ясны согогийг нөхөн сэргээх үйлдлийг судлахаар амьтнаас дээж бэлтгэх, боловсруулах, препарат бэлтгэх нь манай практикт хийгдэж байгаагүй ажил юм.

## **Гурав. СУДАЛГААНЫ АЖЛЫН ПРАКТИК**

### **АЧ ХОЛБОГДОЛ**

Түүшин сэртэнг нөхөн сэргээх “Бреф-Мон” биобэлдмэлийг практикт нэвтрүүлснээр ШТЭӨ-ий үед иж бүрэн эмчилгээ хийх, шүдгүйдлээс үүсэх эрүү нүүрний болон бусад эрхтэн тогтолцооны өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой.

### **Дөрөв. 1. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ**

1. “Бреф-мон биобэлдмэлийн ариун чанарыг судалсан дүн” илтгэл.  
ЭМШУИС-ын НАСС-ийн оюутны эрдэм шинжилгээний хурал.  
Улаанбаатар хот.Тэргүүн байр,Х.Цолмон сангийн нэрэмжит  
шагналтан, 2003.04.09  
  
- 2р шат.АУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээл  
шалгаруулах “Оюутны Эрдмийн чуулган-2003” нэгдсэн хуралдаан,  
Гутгаар байр.Улаанбаатар хот, 2003.04.11
2. “Бреф-Мон биобэлдмэлийн ариун чанар ба ясанд үзүүлэх  
үйлчлэлийг судалсан дүн” илтгэл. Нүүр Ам Судлалын Сургуулийн  
эрдэмтдийн зөвлөлийн эрдэм шинжилгээний бага хурал. Улаанбаатар  
хот.Тэргүүн байр. 2006.03.17  
  
- 2р шат. “Эрдмийн чуулган-48”, Улаанбаатар хот, 2006,04,20
3. “Бреф-Мон биобэлдмэлийн ясанд үзүүлэх үйлчлэлийг судалсан дүн”,  
илтгэл. ШЭНЭСТ-20жил, эрдэм шинжилгээний бага хуралд,  
2006.04.15.

## **4.2 ХЭВЛЭЛД НИЙТЛҮҮЛСЭН БАЙДАЛ**

1. “Бреф-Мон биобэлдмэлийн ариун чанар ба ясанд үзүүлэх үйлчлэлийг судалсан 3 сарын дараах үр дүн”,эрдэм шинжилгээний өгүүлэл, INNOVATION сэтгүүлд , 2005 он, хуудас 49-50
2. “Бреф-Мон биобэлдмэлийн ариун чанар ба ясанд үзүүлэх үйлчлэлийг судалсан дүн” эрдэм шинжилгээний өгүүлэл. Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүлд, 2006 он, хуудас 14-16